

МОНГОЛ БИЧГИЙН СЭРГЭЛТИЙГ УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ӨНЦГӨӨС АВЧ ҮЗЭХҮЙД

Г.ЦЭНД-АЮУШ

МУИС. Улс төр судлалын тэнхимийн доктор,
дэд профессор

Н.ХАСЧУЛУУ

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Монгол улс, Парламентын засаглалт Бүгд Найрамдах улс, улс төрийн соёл, Монгол бичгийн сэргэлт, өв, Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа

Хураангуй: Монголчууд монгол бичгийг дуртайдаа крилл бичгээр сольсон нь үгүй. Харин захиргаадлын засаглалын тогтолцооноос үүдэн Коминтерний шахалтаар өөрсдийн үеийн үед ашиглаж ирсэн хэл соёлын үнэт зүйл болсон үндэсний бичгээ аргагүйн эрхэнд сольсон болно. 1990 оны Монголд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн үр дүнд үндэсний өв соёлоо дээдлэх шудрага ёсны үзэл баримтлал дэлгэрч Монгол эх бичиг, соёлоо сэргээн хэрэглэх ард түмний ухамсар соёл дахин сэргэсэн юм.

* * *

Өнөөгийн даяаршлын эрин үед Монгол улс нээлттэй хөгжих хэрэгтэй ч хадгалж хамгаалах ёстой үндэсний хэл соёлынхоо үнэт зүйлс, улс үндэстнийхээ язгуур эрх ашигт нийцсэн бодлого зарчмын уламжлалаа хойч үедээ залгамжлуулах асуудал онцгой ач холбогдолтой билээ. Аливаа ард түмэн хүссэн тэр зүйлээ өөрсдөө бүтээж, үйл хэргээ гадаад хүчнээс хамгаалж өөрийгөө бодитжуулж байгаагаараа зан суртахуунлаг, буянлаг, хүчирхэг байдаг¹ гэж Германы гүн ухаантан В.Ф.Гегель тэмдэглэсэн байдаг. Учир нь ард түмэн нийгэм, түүхээ бүтээгчид байдаг. Иймд бидний монгол түмэн эх нутаг, үндэс угсаа, хэл соёл, уламжлалын үнэт зүйлс, төрт ёсоо дээдлэх үндэстэн хэвээр байх нь нэн чухал улс төрийн үнэт зүйл мөнөөс мөн². “Дуудах нэрийг эцэг эхээс олж, дурсагдах нэрийг өөрөөсөө олж” чадсан Грекийн сэтгэгч Аристотель улс төр хийгээд нийтийн сайн сайхны шүтэн барилдлагыг онцгой анхааран судалж³, философи ухагдахууны үүднээс нийгмийн найрсал, тэгш байдал, төрийн шударга ёс хангагдаж байх эсэхэд шинжилгээ хийсэн анхдагч сэтгэгчийн нэг.

Монгол Улс парламентын засаглалтай, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, иргэний оролцоотой ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлуулах эрхэм зорилгыг үндсэн хуулиар шийдүүлж⁴ эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хэзээд бэхжүүлж байхын төлөө “үндэсний эв нэгдэл” онцгой чухалчлагдсан суурин дээр “төр ёс, түүх соёлын уламжлалыг нандигнан өвлөх”⁵, “монгол хэл бичиг төрийн албан ёсны хэл мөн” гэх заалтууд шинэ үндсэн хуулиар батлагдан мөрдөгдөж байна.

Монгол улсад хэт үзэл сурталжсан захиргаадлын он жилүүдэд монголчуудын түүх соёл, зан үйл, монгол бичиг, шашин суртахууныг мартагдуулах, орхигдуулах аюул заналхийллийг бий болгож, олон зууны тэртээгээс уламжлагдаж ирсэн тэрхүү оюуны үнэт зүйлс, бүтээл туурвилыг балартуулсныг тухайн үеийн нам, төрийн алдаатай бодлогын уршигт үр дагавар, Коминтерны шаардлага шахалтын нөлөө байсан гэдэгтэй маргах нэгэн гарахгүй болов уу.

“Зөв монгол хүүхэд”-ийг мянга илүү жил монгол ахуй амьдрал, соёл иргэншил, ёс заншлын ариун дагшин хөрсөн дээр бойжуулж чадсан монгол бичгийг төрийн албан хэрэг, нийгмийн өргөн дэлгэр хэрэглээнээс өшиглөн зайлуулж, монгол түмний дуугүй эсэргүүцлийн дунд кирилл цагаан толгойгоор сольсон нь тухайн үеийн хэт туйлширсан славчлалтын хөдөлгөөнд Монгол Улсыг албадан оролцуулахад хүргэжээ. Тухайн үеийн туйлширсан үзэлтнүүд кирилл бичгийг монголчуудад захиргаадан сургахын тулд монгол бичгээс есөн шидийн өө эрж олсон байдаг. Тухайлбал,

¹ Эрх чөлөө ба философи. УБ., 2000.9-р тал

² Социологийг үндэслэгч суутнууд. УБ., 2006. 192,216-р тал

³ И.Амарсанаа нар "Монгол улсын Үндсэн хууль" Үндэстний эрх чөлөөний хувьсгалын 100 жил. Шинэ Үндсэн хуулийн 20 жилийн ойд зориулав. УБ., 2011. 169-174-р тал. /Монгол бичгийн хэвлэл/

⁴ Мөн тэнд

⁵ Мөн тэнд

- Ардын дайсан «хар, шар феодал»-ыг сурталчлан ухуулах агуулга зонхилсон
- Бичгийн ба ярианы хэлний зөрчил ихтэйгийн учир сурахад төвөгтэй, цээжлэхэд яршигтай
- Хэтэрхий хуучирсан феодалын бичиг учир орчин цагийн шинжлэх ухаантай харшилдах зүйл олон
- Монгол бичгийн эгшиг авианы зарим дүрс тодорхойгүй тул гадаад улсын хүн буюу газар орны нэр, шинжлэх ухааны мэргэжлийн үг оноосон томоор тэмдэглэхэд оновчгүй
- Босоо бичлэгээрээ орчин үеийн хэвлэлийн машинд тохирохгүй
- Хэл зүйн шинжилгээний талаар Энэтхэг, Төвдийг дуурайснаас социалист шинэ монголын хөгжлийг удаашруулж саатуулах нь зайлшгүй.

Төмөрлөгийн төрөлд багтах шижир алт зэвэнд идэгддэггүйтэй адил монгол хүний хэл аялгууг жам ёсоор нь зуун зуунд авчирсан, монгол амьдрахуй ухааныхаа унаган хөрөнгийг эрин эринд өртөөлөн тээсэн, эх орны нэгдэл, төр улсын мэдлэг, төрт ёсны бахархлын амин сүнсийг харагдуулсан монгол бичиг дайсагнагчиддаа дийлдээгүй билээ. Хятадад 1949 онд коммунист засаг тогтсоноос хойш монгол бичгийг цаазалсангүй одоо болтол мөнгөн дэвсгэрт дээр «хятад улсын ардын банк» гэснийг монгол бичгээр хэвлэж монголчуудын юаний хэрэглээг будилуулдаггүй. Гэтэл хятад бичиг нь нийгмийн хүрээнд давамгай хэрэглэгдэж монгол бичиг дагалдах хэлбэрийнх нь бичиг төдийхөн болгосныг нуух юун!

Улс төрийн соёлын чухал илэрхийлэл болох эх оронч үндэсний үзлийг таслан зогсоохын төлөө том гүрнүүд хүчирхийлэл, албадлагаар өөрийн улс үндэстнийхээ соёл иргэншлээ шахан тулгах, эсвэл ашиг сонирхлоороо сүр үзүүлэн итгүүлж үнэмшүүлэх, тархийг нь угаах гэж бужигнуулах юм бол хамгийн наад зах нь нинжин сэтгэлээсээ гажиж хүмүүний нийгмийг бохирдуулна. Коммунист засаглалын он жилүүдэд «газар бүрийн ардыг нэгтгэх»⁶ суртал ухуулгаараа том жижиг үндэстнүүд адил эрх тэгш байх ёстой гэсэн уриалгаасаа няцаж олон арван жижиг ард түмнийг ЗСБНХУ-д нэгтгэсэн нь хожмоо ардчиллын давалгаагаар ЗХУ-ыг задарч бутрахад хүргэсэн юм. Сталинчдын шууд оролцоотой туйлшрагчдын монгол бичигт эгдүүцдэгийн учир нь монголчууд энэхүү үндэсний уламжлалт бичгийнхээ үнэн тэмдэглэлд Хөх монголын хөх түүхийг зүй ёсоор нь ойлгочихвол Зөвлөлт гүрний үгэнд орохоо болино гэдгийг сэрэмжилсэн байх магадлалтай.

Монгол улсад ардчилал шинэчлэлийн хүчит дэнсэлт, үндэсний ухамсрын ирмүүн дээшлэлт, төрт ёсны сэргэлтийн дүрлэг чангарахыг дагалдан монгол бичгээ эргээн сэргээх, шударга тэмцэл нийгэмд давамгайлсан юм. Ингээд монгол бичгийг гүтгэж муулсан «хуучин», «хоцрогдсон», «уйгаржин», «худам» гэх янз бүрийн нэрийдлийн хэлсийг цагаатгаж энэ сайхан бичгийн монголд амьдрахуй ухааныг олон зуун уламжилж өгсөн ач гавъяаг зарим хүмүүс үл хайхарсан ч улс төрийн ёс суртахуун, чөлөөт ардчиллыг хүлээн зөвшөөрсөн бүх нийтийн ой санамжид монгол бичгийн уламжлалт өв соёл эргэн танигдаж 90-ээд оноос хойших үеийн монголчуудын улс төрийн сэтгэлгээнд томоохон сэргэлт авчирлаа.

Энэ нь чухам монголоо гэсэн ноён нуруутай улс төрийн лидерүүд төрөх таатай орчин бүрэлдэхийн шинж тэмдэг мөн. Үүний үр дагавраар 1990-2016 он хүртэл монгол бичгийн сэргэлтийг үе шаттай урагш ахиулахын тулд монгол улсын төрийн бус байгууллагууд «Монгол бичгийн ардын хүрээлэн», «Үндэсний бичиг үсгийн баяр», «Монголын сайхан бичигтэн» гэх⁷ буяны үйлсийг бүтээхэнд нь Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд даруйхан шуурхай бодлого боловсруулалт явуулж хоёр удаагийн «Монгол бичгийн үндэсний хөтөлбөр» олон улсад чиглэгдсэн гадаад хэргийн харьцаан дээрх монгол бичгийн албаны түлхүү хэрэглээ, арван жилийн ерөнхий боловсролын сургууль дахь монгол бичгийн эрчимтэй сургалт, монгол төрийн даалгавраар иргэдэд олгох албан гэрчилгээ, үнэмлэх бичигт кирилл бичигтэй хавсаргасан монгол бичгийн хэвийн хэрэглээ, төрийн албан тушаалтнаас монгол бичгийн шалгалт авах арга хэмжээ «Монгол хэлний хууль»⁸ батлагдсан зэрэг үйл ажиллагаанд үндэсний ухамсар, соёлыг дээшлүүлэх жанжин шугам туушлагджээ. Үүнд «Хүмүүн бичиг» сонины хамт олон монгол бичгээ оройн чимгээр дээдэлж явах их чармайлтыг хэлэхгүй өнгөрч болохгүй.

Монгол бичгийн сэргэлт тийм ялгам тод шууд шулуун зөнгөөрөө байгаагүй. Нэг талаас социалист сэтгэхүйтэй сэхээтэн албан тушаалтан монгол бичгээс нүүрээ буруулан гэлбэлзэнэ.⁹ Түүнчлэн төр буюу хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиуд монгол бичгийн сургалт дээр хүзүү сунган зүтгэцгээж, их, дээд сургуулийнхны дотор монгол хэлний тэнхимүүд л магнай тэнийн хөдлөлцөж байхад бусад нийгэм, байгалийн шинжлэх ухааны тэнхимүүд монгол бичгээ сургах асуудал дээр толгойн өвчин хөдөлчих юм. Харин англи, испани, герман, орос, франц, япон, хятад солонгос бичгийн сургалтад нүд нүүр нь сэргээд том гүрний хэлийг сурах юм бол цааш нь ертөнцийг танихад тустай гэгцгээдэг. Энэ талаар урд хөршийн монголчуудын

⁶ Бутаки Хироши зохиож Хүсэлийн хятадчилсан "Монголын түүх болон соёл". Хавсралтад "Үнэн сонин"- д нийтлэгдсэн. Хөх хот, 2003. 78-р тал

⁷ С. Дулам. "Хүмүүн бичиг" сонин. 2016.04.22, 3-р тал

⁸ Мон тэнд

⁹ "Хүмүүн бичиг" сонин. "Нэн сонирхолтой маш их эсэргүүцэл тулсан нэн ялангуяа бизнесийн байгууллагууд, зарим яам тамгын газрууд хүртэл хашин хойрго хөдөлж байсан" гэж С. Дулам гуай монгол бичгийн хамаатай ярилцлага өгөхдөө хэлжээ. 2016.04.22, 3-р тал

доторх “соёл”-чууд монгол бичгийн сургалт хэрэглэлд яригдсаар хэнээс өмнө урам нь хугарахтай адил юм. Монголчуудын дундах иймэрхүү ялимгүй дадал заншлыг билгүүн номч Ринчен багштан “Өөрийн юмыг улаар үзэж өрөөлийн юмыг зулаар таньдаг”¹⁰ гэж хурц зэмлэсэн байдаг. Өнөөдрийн монгол улс дахь монгол бичгийн сэргэлт удааширч буй тулгамдсан асуудлыг нийгэм, улс төр, эдийн засаг, соёл боловсролыг улс төрийн өнцгөөс ажиглавал даяаршлын үзэл суртлын тахалд дайрагдаач гэлтэй. Иймээс 2015.07.01-ний өдрөө хүчин төгөлдөр болсон “Монгол хэлний тухай хууль” нь нийгмийн амьдралын хөрсөнд арай хэрэгжээгүй монгол бичгийг зүг бүхнээс нь хавчиж дайрах хачин яриа, хуучин сэтгэлгээ байсаар байна.

- Бид хуучин бичгээ сэргээх юм бол баруунаас хоцрох эрсдэлтэй,
- Бүх нийтээрээ Монгол бичгийг сурч хэрэглэсээр улс орны минь шинжлэх ухааны судлал, хэвлэл мэдээллийн хөгжилтөд тэр чигээрээ чөдөр тушаа болно.
- Хэрвээ монгол бичгийг төрийн албанд цаашид хэрэглэхтэй зэрэг НҮБ-д хэдийн данслуулсан бүх нийтээрээ бичигтэн гэгддэг сайхан алдараа алдана.
- Бид даяаршлын эрин дэх монголчууд болохоор дан ганц монгол бичгээр Өвөр монголтой харьцахгүй нь зүйн хэрэг. Эдийн засаг элгээрээ хэвтсэн өнөө цагт юуны бичиг үсэг гэх вэ? Хичнээн мөнгө төгрөг үрэх бол доо!
- Монгол бичгийн өвд бурханы шашны судрын орчуулга, цадиг намтрын тэмдэглэлээс өөр юу ч үгүй.
- “Юань улсын судар” дахь нухацтай тэмдэглэлийг үндэслэхэд монгол бичиг мөн хүнийх шүү дээ.

Монгол бичиг мөнх тэнгэрийн бичиг. 800-аад жилийн тэртээ энэ сайхан бичгийг эзэн Чингис нийгэм монголчуудад дэлгэрүүлсэн юм. Чингис хаан, монгол бичиг хоёр өнөөдрийн монгол улсын нутгаас бичигтэн цэргийн эрдмийг хослуулан хүн ардаа хэрэглүүлжээ. 13-р зуунд Их Монгол улс хууль эрх зүйн ханамжа хамгаалал, хатуу шийтгэлийг хаан, харцад адилхан эдлүүлэх, хүлээн авсан албан хэргээ биелүүлээгүй түшмэлээс хариуцлага нэхэмжлэх, ямар нэгэн том гүрний эдийн засгийн харьяалалгүй, бие даах хөгжлийг батлах, үндэстний аюулгүйг батлах асуудал дээр хүн төрөлхтний нийгмээс тэрс явагч зарим улсад цэрэ дайны аймшигт ажиллагаа буюу улс төрийн шийдлээр дэг журам гэгчийг таниулах сайн төрийн зарлигаар монгол бичигт тэмдэглэн тунхагласан билээ.

Өнөөдөр монгол соёлын үнэт зүйлсийг төлөөлж чадах монгол бичгээ нандигнан сэргээж, эх хэл дээдлэн сурах нь улс орны тусгаар тогтнолыг улам баталгаажуулж өгөх сайн төрийн хайлт мөн. Монгол бичгийн ач тус нь даруй хэл соёл, монгол ахуйн өртгийг 1000-аад жил унаган төрхөөр нь уламжилж ирсэн оршино. 20-р зууны 50-иад онд Өвөрлөгчдийн дунд кирилл бичигт шилжих асуудал маш их яригджээ. Тухайн жилүүдийн энэхүү бусармаг үйл ажлыг эрс шуурхай эсэргүүцэж байсан билгийн номч Б.Ринчен Хөх хотод очоод Рашидонробтой уулзаж, монгол бичгийн хувь заяаны тухай ар өврийн хоёр эрдэмтэн саналаа солилцжээ. Б.Ринчен Рашидонробт ийм нэг 1920-иад онд болсон хэргийг учирлан ярьжээ. 1929 онд коммунист засаглалыг гэнэн цайлган сэтгэлээр итгэж байсан халимагчууд нэрт монголч эрдэмтэн Владимирцовыг Элстэй хотод урьж, түүнээс шинэ цагт зохицох сайн бичиг зохиож өгөхийг гуйсанд нийт толгой сажиж: «Хиагтын гудамжид зугаалж бүхий хүрээний монгол хүн, Бээжингээр алхсан монгол хүн бие биеэ шууд ойлголцох гайхамшигт бичигтэй ард түмэн шүү! Монголчууд аа! би та бүхэнд зориулалттай ондоо бичиг зохиож чадахгүй ээ» гэж хариулсан гэсэн. Харамсалтай нь коммунизм Зүүн Европ ба Зүүн Ази тэлснээс Владимирцовын дээрх шударга ёсны чиг баримтлал биеллээ олж чадаагүй юм.

Туурга тусгаар Монгол улсад монгол бичиг төрийн бичгээр залагдаж оюуны өргөн дэлгэр хэрэглээ болволгаднынхан Чингисийн монголыг дахин танина. Учир нь даяаршлын эринд аливаа улс үндэстэн өвөрмөц үндэсний хэл соёлоо алдахгүй байх нь үндэсний аюулгүй байдлын гол баталгаа байдаг. Үүнд монгол бичгээх төр улс, төрт ёсны үнэ цэнийг агуулсан эрт эдүгээгийн улс төрийн соёлд бүрэн дүүрэн тодорно.

- Тухайн цагтаа соёлтой гэгдэж байсан найман аймгийнхан монгол бичгийг нэгдсэн монгол улсаас өмнө хэл соёлдоо идээшүүлж Их монгол улсын төрийн албанд түлхүү хэрэглэгдэх бат суурийг тавьж өгсөн түүхийн баримт байдаг.
- Монгол бичиг XIII-XV зуун дуустал олон улсын харилцаанд тохирох хууль эрх зүйн дагуу албан хэрэглээний үүргээ гүйцэтгэж байжээ.
- Монгол бичиг нь монгол хэлний язгуур, үндэс, дагавар, тийн ялгал, хамаатуулах ёсны зөв бичлэгийг нэгэнтээ онолжуулж, тогтворжуулж монгол үндэстний олон нутгийн аялгууг харгалзах ардач чанартай.
- Монгол ахуй, монгол бичиг, монголын төр улс түүхэн улс төрийн хувь заяагаар холбогдсон монгол үндэстний бахархалын билэг тэмдэг байж ирсэн монгол улс энхжин жаргах тулгын гурван чулуу билээ. Монгол улс Ази тивд мэндэлснээрээ дорнын соёл иргэшлийн өнөр баян түүхэн уламжлалтай юм. Ийнхүү агуу их Чингис хааны ивээж соёрхсон монгол бичгээ Монгол улс түлхүү нандигнах нь 21-р зууны даяаршилд өөрийн гэх соёл иргэншлээрээ бусдаас ялгагдаж хөгжих нөхцөл мөн бөлгөө.

¹⁰ “Монгол хэл бичиг” сэтгүүл. УБ., 1984, “Эх хэлний манаа” булангийн “Б.Ринчин. Эх хэлээ эрхэмтгэ”

Abstract: The use of Mongolian Script and political culture have been lost due to the socialist governing that was subjected to political repression of 40s of 20th century. However, The Mongolian Parliamentary Republic was proclaimed, in the beginning of the 20th century, around 1990s and the conscious of tradition have revoked the Mongolian Old Script in order to fit into Political culture that is to approve the independence and national security.

НОМ ЗҮЙ:

1. Ц.Ган-Өлзий “Шударга ёсны иш онол” Монгол улсын шинжлэх ухааны академи. Философи, социализм, эрх зүйн хүрээлэн. УБ., 2012.
2. Улс төрийн шинжлэх ухаан. УБ., 2014.
3. Ж.Цэвээн «Улсын эрх», «Эрх зүйт ёс, сан» УБ., 2014.
4. Жигдэнгомбын Цэцэн «Монгол ном зүйн онол түүхийн зарим асуудал» Соёл урлаг судлалын хүрээлэн. УБ., 2002.
5. Ж.Бор, Д.Баатар. «Монголын улс төр» УБ., 2012.
6. Н.Хавх. «Монголын нийгмийн гүн ухаан» Монгол судлал цуврал. Хөх хот. 2013.
7. Г.Цэнд-Аюуш. Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа. УБ., 2012.